

ТАНИЛЦУУЛГА

*Хүнсний гол нэрийн барааны үнэ,
2014 оны 2-р сарын 26-ны байдлаар*


2014 оны 2-р сарын 26-ны байдлаар хүнсний гол нэрийн барааны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад 0.7 хувь, өмнөх 7 хоногийнхоос 0.6 хувиар өссөн байна.

Махны дундаж үнэ: 2014 оны 2-р сарын 26-ны байдлаар хонины ястай махны үнэ өмнөх сарынхаас 2.2 хувь, үхрийн ястай мах 2.4 хувь, үхрийн цул мах 1.9 хувиар буурч, адууны мах 0.7 хувь, ямааны мах 0.2 хувиар өссөн байна.

Өмнөх 7 хоногийнхоос хонины ястай махны үнэ 0.3 хувь, үхрийн ястай мах 0.1 хувиар өсч, үхрийн цул мах, адууны мах, ямааны махны үнэ өөрчлөлтгүй байна.

2014 оны 2-р сарын 26-ны байдлаар 1 кг хонины /ястай/ мах дунджаар 6700 төгрөг, үхрийн /ястай/ мах 7790 төгрөг, үхрийн цул мах 9640 төгрөг, адууны мах 6475 төгрөг, ямааны мах 5560 төгрөгийн үнэтэй байв (Зураг 1).

Зураг 1. Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ




Гурилын үнэ: 2014 оны 2-р сарын 26-ны байдлаар дээдийн дээд зэргийн савласан гурилын үнэ өмнөх сарынхаас 7.1 хувь, 2-р зэргийн гурилын үнэ 0.8 хувиар өсч, дээд зэргийн савласан гурилын үнэ 0.4 хувиар буурч, 1-р зэргийн задгай гурилын үнэ өөрчлөлтгүй байна.

Өмнөх 7 хоногийнхоос дээдийн дээд зэргийн савласан бүх төрлийн гурилын үнэ өөрчлөлтгүй байлаа.

Будаа, элсэн чихрийн дундаж үнэ: 2014 оны 2-р сарын 26-ны байдлаар элсэн чихрийн үнэ өмнөх сарынхаас 0.6 хувиар буурч, өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна.

Цагаан будааны үнэ өмнөх сарынхаас 3.5 хувь, өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна. (Зураг 2).

Зураг 2



Төмс, хүнсний ногооны дундаж үнэ: 2014 оны 2-р сарын 26-ны байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад сонгино 2.7 хувь, байцаа 3.2 хувь, лууван 4.2 хувь, төмс 4.4 хувиар өсч, манжин 0.6 хувиар буурсан байна.

Өмнөх 7 хоногийнхоос байцаа 2.8 хувь, сонгино 3.1 хувь, лууван 5.4 хувь, төмс 6.1 хувиар өсч, манжингийн үнэ өөрчлөлтгүй байна.

Сүү, өндөг, ургамлын болон цөцгийн тосны дундаж үнэ: 2014 оны 2-р сарын 26-ны байдлаар өмнөх сарынхаас задгай сүүний үнэ 1.0 хувь, савласан /1 литрийн/ сүүний үнэ 10.0 хувь, “Элекстер” /0.5 л/ савласан сүүний үнэ 8.0 хувиар өсч, өмнөх 7 хоногийнхоос “Элекстер” /0.5 л/ савласан сүүний үнэ 1.6 хувиар буурч, задгай сүүний үнэ, савласан /1 литрийн/ сүүний үнэ өөрчлөлтгүй байна.

Ургамлын тосны үнэ өмнөх сарынхаас 0.3 хувиар өсч, өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байв. Цөцгийн тосны үнэ өмнөх сарынхаас 1.1 хувиар өсч, өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна.

Өндөгний үнэ өмнөх сарынхаас 1.2 хувиар буурч, өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна.

Хүнсний гол нэрийн барааны үнэ, аймгаар

Хүнсний гол нэрийн барааны 7 хоногийн үнийн судалгаанд аймгийн төвүүдээс гурил, мах, цагаан будаа, малын сүү, элсэн чихрийн үнийг судалдаг (Хавсралт хүснэгт 3).

Гурилын үнэ: 2014 оны 2-р сарын 26-ны байдлаар аймгийн төвүүдийн хүнсний зах, дэлгүүрт хэрэглээ ихтэй 1-р зэргийн гурилын үнэ 640-1100 төгрөгийн хооронд худалдаалагдаж байна. Гурилын үнэ өмнөх 7 хоногийнхоос бүх аймагт өөрчлөлтгүй байна.

Дорнод аймагт 1-р зэргийн гурилын үнэ хямд буюу 680 төгрөг байхад, Завхан аймагт 1100 төгрөг байгаа нь өндөр үнэ байна.

Махны үнэ: 2014 оны 2-р сарын 26-ны байдлаар хонины махны үнэ өмнөх 7 хоногийнхоос Увс, Баянхонгор, Өвөрхангай, Хөвсгөл, Дархан-Уул, Дундговь, Сүхбаатар аймагт 200-1000 төгрөгөөр өсч, Архангай аймагт 500 төгрөгөөр буурсан байна.

Хонины махны үнэ Хөвсгөл аймагт 8500 төгрөг байгаа нь өндөр бөгөөд Баян-Өлгий аймагт 5500 төгрөг байгаа нь хамгийн хямд үнэ байв.

Үхрийн махны үнэ өмнөх 7 хоногийнхоос Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл, Дархан-Уул, Сүхбаатар аймагт 140-500 төгрөгөөр өсч, Архангай аймагт 500 төгрөгөөр буурсан байна. Үхрийн махны үнэ Дорноговь аймагт 9500 төгрөг байгаа нь хамгийн өндөр үнэ бөгөөд Баян-Өлгий аймагт 5000 төгрөгөөр худалдаалагдсан нь хямд үнэ байв.

Ямааны махны үнэ Архангай, Баянхонгор, Өвөрхангай, Хөвсгөл, Дорнод, Сүхбаатар аймагт 200-500 төгрөгөөр өсч, Баян-Өлгий, Увс аймагт 170 төгрөгөөр буурсан байна. Ямааны мах Баян-Өлгий аймагт хямд буюу 4500 төгрөг байхад Ховд аймагт 6500 төгрөг байгаа нь хамгийн өндөр үнэ байна.

Малын сүүний үнэ: 2014 оны 2-р сарын 26-ны байдлаар малын сүү аймагт 1200-3000 төгрөгийн үнэтэй худалдаалагдсан байна. Сүүний үнэ Архангай, Баянхонгор, Сэлэнгэ, Сүхбаатар аймагт 100-200 төгрөгөөр өсч, Хөвсгөл аймагт 100 төгрөгөөр буурсан байна. Өмнөговь аймагт хамгийн /3000 төг/ өндөр үнэтэй байна.

Цагаан будаа, элсэн чихрийн үнэ: 2014 оны 2-р сарын 26-ны байдлаар цагаан будааны үнэ өмнөх 7 хоногийнхоос бүх аймагт өөрчлөлтгүй байна. Нийт аймагт цагаан будаа 1 кг нь 1900-2400 төгрөгийн хооронд худалдаалагдаж байна.

Элсэн чихрийн үнэ өмнөх 7 хоногийнхоос Дорноговь, Өмнөговь аймагт 30-70 төгрөгөөр буурсан байна. Элсэн чихэр 1 кг нь 1500-2000 төгрөгийн хооронд худалдаалагдаж байна.